



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бугат сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит



Аудитын код: БУА-2021/134/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Булган аймаг 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: <a href="mailto:Anhbayard@audit.gov.mn">Anhbayard@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: <a href="mailto:Enhtsoodolj@audit.gov.mn">Enhtsoodolj@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: П.Содном Утас: 70342495 Цахим хаяг: <a href="mailto:Sodnomp@audit.gov.mn">Sodnomp@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: <a href="mailto:Suvdaaa@audit.gov.mn">Suvdaaa@audit.gov.mn</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

<b>УСНББОУС</b>	<b>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</b>
<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>АОУС</b>	Аудитын Олон Улсын Стандарт



## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	11
3.Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	13
3.4. Материаллаг байдал .....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Залруулсан алдаа.....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	16
Аудитын зөвлөмж.....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	17
4. Менежментийн захидал .....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	<b>Error! Bookmark not defined.</b>

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,  
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.09.15 № 99  
Танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_ Т

БУЛГАН АЙМГИЙН БУГАТ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ч.ОДОНТУЯА ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын ЗДТГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Аудитын гол асуудал

Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчил нь санхүүгийн тайланд материаллаг бөгөөд өргөн тархаагүй байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" заалт, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 1.3 дахь "Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана" гэсэн заалтыг зөрчин цалингийн зардлаас 450.0 мянган төгрөгийг ахмадад хүндэтгэл үзүүлсэн нь санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тайлант онд 5641.7 мянган төгрөгийн авлага, 1173.7 мянган төгрөгийн өглөг нэмэгдэж 6858.9 мянган төгрөгийн авлага, 1487.0 мянган төгрөгийн өглөгийн үлдэгтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг

006020203

зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

- Анхан шатны баримтгүй шатахуун зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй
- Жолоочийн тооцооны хуудсыг түүвэрлэн үзэхэд Засгийн газрын 2019 оны 390 дүгээр тогтоолыг зерчин нийт 880.6 мянган төгрөгийг шатахуунд үргүй зардал гаргасан байна.
- ЗДТГ-ын худалдааны төвийг түрээслүүлсэн гэрээ /анхан шатны баримт/ байхгүй, тооцоо нийцсэн актгүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 13.6 дахь заартыг хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн аудитын эрх ба үүрэг, үнэн, зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.
- Бэлэн мөнгөний дансаар нийт 24115.7 мянган төгрөгийг шилжүүлж гүйцэтгэлээр 19652.2 мянган төгрөгийн анхан шатны баримттай, 5015.9 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, архивын нэгж үүсгээгүй нь санхүүгийн тайлангийн аудитын иж бүрэн байх, үнэлгээ, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

СТ-1А

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>67,099,140.15</b>	<b>81,951,536.50</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	780,800.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	780,800.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	780,800.00
31213	Арилжааны банк дахь харилцах	-	780,800.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,217,224.40	6,858,890.75
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	5,264,335.65
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	1,217,224.40	1,594,555.10
3351	Байгууллагаас авах авлага	1,217,224.40	1,594,555.10
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	65,881,915.75	74,311,845.75
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	41,361,915.75	49,791,845.75
35410	Бичиг хэргийн материал	922,985.00	2,725,985.00
35420	Аж ахуйн материал	35,710,980.75	44,015,060.75
35430	Сэлбэг хэрэгсэл	568,000.00	3,050,800.00
35440	Түлш, шатах тослох материал	4,159,950.00	-
35600	Мал амьтад	24,520,000.00	24,520,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,160,246,447.15</b>	<b>1,094,039,369.44</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,160,246,447.15	1,094,039,369.44
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,026,854,447.15	960,827,369.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	858,975,758.10	858,975,758.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	(147,099,726.83)	(189,221,870.95)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	215,983,983.37	215,983,983.37
39204	Хуримтлагдсан элэгдэл	(139,490,366.95)	(156,217,833.59)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	135,173,783.68	100,797,320.35
39206	Хуримтлагдсан элэгдэл	(100,734,464.04)	(40,076,200.17)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,859,994.45	26,732,738.12
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,530,827.65)	(14,574,880.16)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	16,280,000.00	16,280,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	274,882,958.28	274,882,958.28
39215	Хуримтлагдсан элэгдэл	(98,331,245.26)	(133,619,203.91)
39217	Ном	884,600.00	884,600.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	133,392,000.00	133,212,000.00
39301	Програм хангамж	3,495,500.00	3,495,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,595,500.00)	(2,775,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	132,492,000.00	132,492,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,227,345,587.30</b>	<b>1,175,990,905.94</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>313,319.65</b>	<b>1,487,040.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	313,319.65	1,487,040.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	313,319.65	1,487,040.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	313,300.35	50,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	19.30	303,840.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	1,133,200.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,133,200.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,227,032,267.65</b>	<b>1,174,503,865.94</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,227,032,267.65	1,174,503,865.94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	667,249,599.55	667,249,599.55
51101	Өмч: - төрийн	667,249,599.55	667,249,599.55
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	112,105,006.48	59,576,604.77
51210	Өмнөх үеийн үр дүн	112,105,006.48	112,105,006.48
51220	Тайлант үеийн үр дүн	-	(52,528,401.71)

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	447,677,661.62	447,677,661.62
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,227,345,587.30</b>	<b>1,175,990,905.94</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>602,794,594.00</b>	<b>460,730,934.13</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,377,000.00</b>	<b>36,353,516.13</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,377,000.00	36,353,516.13
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,377,000.00	36,353,516.13
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,947,000.00	4,312,865.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	430,000.00	32,040,651.13
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>599,417,594.00</b>	<b>424,377,418.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	177,135,500.00	34,407,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	136,936,800.00	-
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	30,517,600.00	-
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	9,681,100.00	34,407,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	104,569,094.00	37,648,418.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	30,144,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,569,094.00	5,602,349.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,901,569.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	317,713,000.00	352,321,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	317,713,000.00	352,321,100.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>532,795,023.93</b>	<b>515,029,635.84</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>532,795,023.93</b>	<b>515,029,635.84</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	524,447,979.93	508,931,246.31
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	212,781,817.14	228,921,107.18
210101	Үндсэн цалин	138,815,514.14	155,870,452.38
210102	Нэмэгдэл	33,278,930.00	31,187,423.80
210105	Гэрээт ажлын хөлс	40,687,373.00	41,863,231.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	26,428,125.00	29,503,826.82
210201	Тэтгэврийн даатгал	17,984,180.00	19,859,299.10
210202	Тэтгэмжийн даатгал	2,115,788.00	2,349,684.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,687,509.00	1,813,429.73
210204	Ажилгүйдлийн даатгал	421,876.00	478,260.51
210205	Эрүүл мэндийн даатгал	4,218,772.00	5,003,152.55
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,681,910.30	28,450,755.47
210301	Гэрэл, цахилгаан	9,751,561.00	8,753,923.47
210302	Түлш, халаалт	9,830,349.30	19,696,832.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	22,157,242.00	27,419,260.00
210401	Бичиг хэрэг	1,876,715.00	4,008,350.00
210402	Тээвэр, шатахуун	18,734,587.00	15,032,450.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,545,940.00	1,629,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	6,748,860.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,947,900.00</b>	<b>15,936,870.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	338,500.00	-
210604	Урсгал засвар	3,609,400.00	15,936,870.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>20,753,620.00</b>	<b>3,934,000.00</b>
210701	Гадаад албан томилолт	-	3,000,000.00
210702	Дотоод албан томилолт	20,753,620.00	934,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,882,496.00</b>	<b>3,505,309.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,066,900.00	2,554,849.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	108,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	379,440.00	379,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	131,156.00	124,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	197,000.00	122,860.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>215,814,869.49</b>	<b>171,260,117.84</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	96,288,746.60	52,419,089.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,311,300.00	14,543,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	115,214,822.89	104,297,628.84
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,347,044.00</b>	<b>6,098,389.53</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,761,576.00</b>	<b>-</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,761,576.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,585,468.00</b>	<b>6,098,389.53</b>
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	3,585,468.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,098,389.53
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>69,999,570.07</b>	<b>(54,298,701.71)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>14,970,514.43</b>	<b>-</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	14,970,514.43	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(14,970,514.43)</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>55,029,055.64</b>	<b>(54,298,701.71)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

#### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>434,910,194.00</b>	<b>428,690,283.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,947,000.00</b>	<b>4,312,865.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,947,000.00	4,312,865.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	2,947,000.00	4,312,865.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,947,000.00	4,312,865.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>431,963,194.00</b>	<b>424,377,418.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	34,407,900.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих		34,407,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	104,569,094.00	37,648,418.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	402,500.00	

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,839,980.00	30,144,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	63,326,614.00	5,602,349.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,901,569.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>327,394,100.00</b>	<b>352,321,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	327,394,100.00	352,321,100.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>419,094,494.00</b>	<b>421,859,583.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>419,094,494.00</b>	<b>421,859,583.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>410,747,450.00</b>	<b>415,761,193.47</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>212,065,826.00</b>	<b>234,273,885.28</b>
210101	Үндсэн цалин	138,099,523.00	153,931,570.20
210102	Нэмэгдэл	33,278,930.00	40,982,823.08
210105	Гэрээт ажлын хөлс	40,687,373.00	39,359,492.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>26,428,125.00</b>	<b>29,678,684.72</b>
210201	Тэтгэврийн даатгал	17,984,180.00	20,284,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,115,788.00	2,348,665.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,687,509.00	1,878,856.73
210204	Ажилгүйдлийн даатгал	421,876.00	469,732.20
210205	Эрүүл мэндийн даатгал	4,218,772.00	4,697,329.86
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>20,969,811.00</b>	<b>22,715,165.47</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,751,561.00	8,926,923.47
210302	Түлш, халаалт	11,118,250.00	13,788,242.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>17,831,798.00</b>	<b>17,746,610.00</b>
210401	Бичиг хэрэг	2,339,300.00	4,094,150.00
210402	Тээвэр, шатахуун	13,880,558.00	12,023,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,611,940.00	1,628,760.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>600,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	600,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,830,200.00</b>	<b>28,275,390.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	429,550.00	-
210604	Урсгал засвар	6,400,650.00	28,275,390.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>20,753,620.00</b>	<b>3,934,000.00</b>
210701	Гадаад албан томилолт	-	3,000,000.00
210702	Дотоод албан томилолт	20,753,620.00	934,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,649,996.00</b>	<b>5,402,809.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,834,400.00	4,452,349.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	108,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	379,440.00	379,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	131,156.00	124,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	197,000.00	122,860.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>101,218,074.00</b>	<b>73,134,649.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	96,862,774.00	48,936,449.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,355,300.00	24,198,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,347,044.00</b>	<b>6,098,389.53</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,761,576.00</b>	<b>-</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,761,576.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,585,468.00</b>	<b>6,098,389.53</b>
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	3,585,468.00	-

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,098,389.53
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>15,815,700.00</b>	<b>6,830,700.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>15,815,700.00</b>	<b>6,049,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>15,815,700.00</b>	<b>6,049,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	15,815,700.00	6,049,900.00
222001	Тоног төхөөрөмж	15,815,700.00	6,049,900.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(15,815,700.00)</b>	<b>(6,049,900.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	780,800.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	780,800.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

### ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	667,249,599.55	447,677,661.62	224,530,350.84		1,339,457,612.01
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>667,249,599.55</b>	<b>447,677,661.62</b>	<b>224,530,350.84</b>	-	1,339,457,612.01
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(112,425,344.36)		(112,425,344.36)
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>667,249,599.55</b>	<b>447,677,661.62</b>	<b>112,105,006.48</b>	-	1,227,032,267.65
D01	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>667,249,599.55</b>	<b>447,677,661.62</b>	<b>112,105,006.48</b>	-	1,227,032,267.65
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>667,249,599.55</b>	<b>447,677,661.62</b>	<b>112,105,006.48</b>	-	1,227,032,267.65
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(52,528,401.71)		(52,528,401.71)
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>667,249,599.55</b>	<b>447,677,661.62</b>	<b>59,576,604.77</b>	-	1,174,503,865.94

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант он	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	385089000.00	384162675.47
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	385089000.00	382712775.47
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	385089000.00	382712775.47
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	234951100.00	234273885.28
210101	Үндсэн цалин	150529500.00	153931570.20
210102	Нэмэгдэл	43180700.00	40982823.08
210105	Гэрээт ажлын хөлс	41240900.00	39359492.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29689900.00	29678684.72
210201	Тэтгэврийн даатгал	20284100.00	20284100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2351400.00	2348665.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	1881200.00	1878856.73
210204	Ажилгүйдлийн даатгал	470300.00	469732.20
210205	Эрүүл мэндийн даатгал	4702900.00	4697329.86
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	22715300.00	22715165.47
210301	Гэрэл, цахилгаан	8927000.00	8926923.47
210302	Түлш, халаалт	13788300.00	13788242.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16961000.00	16179710.00
210401	Бичиг хэрэг	4875000.00	4094150.00
210402	Тээвэр, шатахуун	10457200.00	10456800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,628,800.00	1,628,760.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	600,000.00	600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	600,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	27,093,100.00	28,275,390.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-
210604	Урсгал засвар	27,093,100.00	28,275,390.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,128,100.00	3,934,000.00
210701	Гадаад албан томилолт	3,000,000.00	3,000,000.00
210702	Дотоод албан томилолт	1,128,100.00	934,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,250,500.00	2,850,460.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,300,000.00	1,900,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	379,400.00	379,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	124,200.00	124,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	122,900.00	122,860.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	45,700,000.00	44,205,480.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,500,000.00	20,007,280.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,200,000.00	24,198,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>1,449,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	1,449,900.00
222001	Тоног төхөөрөмж	-	1,449,900.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	385,089,000.00	350,535,575.47
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	-
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	352,587,300.00	346,222,710.47
132001	Орон нутгийн төсвөөс	352,587,300.00	346,222,710.47

<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	-
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	32,501,700.00	4,312,865.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.00	4,312,865.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	31,001,700.00	-
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>780,800.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	25.00	25.00
620001	Удирдах ажилтан	6.00	6.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00
620004	Гэрээт ажилтан	7.00	7.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>32.00</b>	<b>32.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	9.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11.00	11.00
650010	Гэрээт ажилтан	7.00	7.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	5.00	5.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

НТ-2

### НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>37,648,418.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>33,048,418.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	33,048,418.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	1,566,900.00
210402	Тээвэр, шатахуун	-	1,566,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	2,552,349.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,552,349.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	28,929,169.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	28,929,169.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>4,600,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	-	4,600,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	4,600,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	37,648,418.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	37,648,418.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	30,144,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,602,349.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,901,569.00

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Бугат сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Бугат сумын Тамгын дарга Ч.Отгонтуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн нийцэл, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 23-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хоёр дахь шатны, аудитын менежер Ж.Энхцоодол, ахлах аудитор П.Содном нар анхан шатны хяналтыг тус тус хэрэгжүүлэн, аудитор А.Сувдаа хариуцан гүйцэтгэв.

Бугат сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь төрийн аудитын газар-т 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02/26 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Тус байгууллага тайланд онд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг сайжруулж, иргэдийн өргөдөл гомдлыг бүрэн шийдвэрлэх
- Засаг дарга, Тамгын газрын даргаас гарах шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэлийг хангаж ажиллах
- Албан хаагчдын мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх хүрээнд улс, аймаг, бүс, орон нутгийн сургалтад тухай бүр хамруулах
- Байгууллагын үйлчилгээний стандарт, дотоод журмын хэрэгжилтийг хангуулах
- Иргэдэд үзүүлэх үйлчилгээний шуурхай байдлыг нэмэгдүүлэх
- Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнг дээшлүүлэх
- Байгууллагын албан хаагчдын ажиллах, иргэдэд үзүүлэх үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоол
- Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2020 оны А/106 дугаар
- Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 114 дүгээр тогтоол
- Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай Засгийн газрын 163 дугаар тогтоол,

- Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зохицуулалтын эрх олгох тухай Засгийн газрын 187 дугаар тогтоол

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Бугат сумын ЗДТГ-ын газар санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “10300.6 мянган төгрөг” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн тайлангийн нийт зардлын 312985.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 6259.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Бугат сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 51354.7 мянган төгрөгөөр буюу 4.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	780.8	780.8
Авлага	1217.2	6858.9	5641.7
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	65881.9	74311.8	8429.9
Үндсэн хөрөнгө	1160246.4	1094039.4	-66207.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1227345.6</b>	<b>1175990.9</b>	<b>-51354.7</b>
Өр төлбөр	313.3	1487.0	1173.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1227032.3	1174503.9	-52528.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1227345.6</b>	<b>1175990.9</b>	<b>-51354.7</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 780.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 1217.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 6858.9 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 74311.8 мянган төгрөг болж 8429.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант хугацааны эцсийн үлдэгдлээр 2725.9 мянган төгрөгийн бичиг хэрэг буюу 195.0 хувь, 44015.1 мянган төгрөгийн аж ахуйн материал буюу 23.0, 3050.8 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл буюу 437.0 хувиар өмнөх оны үлдэгдлээс их буюу материалын нөөц үүсгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1094039.4 мянган төгрөг болж 66207.1 мянган буурсан нь 10496.8 мянган төгрөгийн хөрөнгө акталсан, 72097.5 мянган төгрөгийн хөрөнгийг хасаж дахин үнэлгээгээр 32040.7 мянган төгрөгөөр орлогоор хүлээн авснаас шалтгаалжээ.

Биет бус хөрөнгөнд өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1487.0 мянган төгрөг болж 1173.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1175990.9 мянган төгрөг болж 51354.7 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгө акталсан, дахин үнэлгээ хийснээс шалтгаалжээ.

Бугат сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 142453.6 мянган төгрөгөөр буюу 23.5 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 17765.4 мянган төгрөгөөр буюу 3.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан томилолт, зочны зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 393116.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 393116.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 8027.3 мянган төгрөгөөр бууруулж 358089.0 мянган төгрөгөөр баталсан байна. Материаллаг хэмжээгээр цалин хөлс болон нэмэгдэл урамшил 158165.2 мянган төгрөгөөр бууруулж, эд хогшил, урсгал засварын зардал 27093.1 мянган төгрөгөөр өсгөсөн өөрчлөлттэй байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 385089.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 352587.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 1500.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор, урьд оны үлдэгдлээс 31001.7 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 380630.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 4312.9 мянган төгрөг, нийт 384943.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 384162.7 мянган төгрөгийг зарцуулж 6098.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 384162.7 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 677.2 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 781.3 мянган төгрөгөөр, эд хошиг урсгал засварын зардал (1182.3) мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал 400.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээ 926.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна. /

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.6-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 30144.5, дээд шатны төсвийн захирагчаас 5602.3 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1901.6 мянга, нийт 37648.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тээвэр шатахуунд 1566.9, бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил үйлчилгээний зардалд 2552.3, бараа үйлчилгээний бусад зардалд 28929.2, тоног төхөөрөмжид 4600.0 нийт 37648.4 мянган төгрөгийг зарцуулжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 110 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 4 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш дүнтэй 37 удаагийн 408891.6 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 468.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн актыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 3428.3 мянган төгрөгийн 6 зөвлөмжийн хэрэгжилт 83.3 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	468.9	1	468.9	0	0	0
Албан шаардлага	0	0	0	0	0	0	0
Зөвлөмж	6	3428.3	5	3428.3	1	0	16.7
Нийт дүн	7	3897.2	6	3897.2	1	0	16.7

/мянган.төг/

Хэрэгжүүлээгүй 1 зөвлөмжид албан шаардлага хүргүүлэхээр болов.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 19651.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1526.6 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 13811.8 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 4312.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

#### **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулгыг хийгээгүй болно.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 15338.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1526.6 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 13811.8 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1.Цалингийн зардлаас 450.0 мянган төгрөгийг ахмадад хүндэтгэл үзүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” заалт, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 1.3 дахь “Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

2. Тайлант онд 6858.9 мянган төгрөгийн авлага, 1487.0 мянган төгрөгийн өглөгийн үлдэгтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

3. Анхан шатны баримтгүй 646.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.6. Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

4. Жолоочийн тооцооны хуудсыг түүвэрлэн үзэхэд Засгийн газрын 2019 оны 390 дүгээр тогтоолыг зөрчин нийт 880.6 мянган төгрөгийг шатахуунд үргүй зардал гаргасан нь үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

5. Бэлэн мөнгөний дансаар нийт 24115.7 мянган төгрөгийг шилжүүлж гүйцэтгэлээр 19652.2 мянган төгрөгийн анхан шатны баримттай, 5015.9 мянган төгрөгийн баримтын бүрдэл дутуу, архивын хадгаламжийн нэгж болгоогүй нь НББ-ийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн баримт болон санхүүгийн тайланг архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол 10-аас доошгүй жил хадгална”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны

баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэж заасныг зөрчсөн, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

6.Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд зааврын дагуу үнэн зөв, чанартай явуулж тооллогын явц үр дүнг комиссын хурлаар хэлэлцэж, тооллогын бүртгэлийг 2 хувь үйлдэж байгууллагын удирдлагад танилцуулан батлуулж, санхүүгийн албанд хүргүүлэх үүрэгтэй байдаг ч баримтын бүрдэл, тооцоолол дутуу Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4 дэх "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 4312.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

**3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг анхаарахаас гадна дотоод хяналт, шалгалт бүтэц зохион байгуулалтын талаар анхаарах нь зүйлтэй гэж үзлээ.

**4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*1. Орлого данстай холбоотой асуудал*

- 1.1. Илрүүлэлт: ЗДТГ-ын худалдааны төвийг түрээслүүлсэн гэрээ /анхан шатны баримт/ байхгүй, тооцоо нийцсэн актгүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.
- 1.2. Эрсдэл: Төлөвлөсөн орлого тасрах, хууль журам зөрчигдөх
- 1.3. Өгсөн зөвлөмж: НББ-ийн тухай хуулийн холбогдох заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

*2. Худалдан авалттай холбоотой асуудал*

2.1. Илрүүлэлт: Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас НӨАТ-ын баримтгүйгээр 48835.7 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 347 тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй нь эрх ба үүрэг, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх, орлогыг нуун дарагдуулах, тайлагнахгүй байх

Бугат сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.3. Өгсөн зөвлөмж: НӨАТ тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.3.2, 17.6 заалтуудыг мөрдөж, анхан шатны баримтыг И баримтаар бүрэн баталгаажуулж хэвших.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

3. Шилэн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Төсвийн хэтрэлт, хэмнэлтийн тайлбарыг огт мэдээлээгүй, хугацаа хоцроосон 4 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш дүнтэй 30 удаагийн 350277.4 мянган төгрөгийн орлого, 7 удаагийн 58614.2 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.

3.2. Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх, мэдээлэл дутуу хүрэх

3.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6.1.6, 6.4.5, Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 2.2.1.6, 2.2.1.13 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАН ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР



Д.АНХБАЯР  
Ж.ЭНХЦООДОЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР

А.СУВДАА